



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургууль 2023 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2024/96/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Дархан-Уул аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр: Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: С.Батцэцэг Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ч.Мөнхбаяр Утас: 89275858 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт .....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОУС	Олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45059,  
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089  
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

додч од.дб № 97

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын үнэлгээний төвийн сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн үнэлгээгээр 4 дүгээр шатлалд шалгарч 7,187.5 мянган төгрөгийн мөнгөн урамшуулал авсан байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 57,591.8 мянган төгрөг, ажил олгогч нийгмийн даатгалд төлөх шимтгэл 8,177.3 мянган төгрөг, нормативт зардал 3,437.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 1,069.0 мянган төгрөгийг хэмнэснээс зарцуулагдаагүй 70,275.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна

## **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.2%-р тайлагнасан байна. Мөн улирал бүр БСУГ-т ажлын тайланг хүргүүлж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	152,483,845.88	265,855,026.60
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	77,256,959.18	147,532,165.90
311	Кассанд байгаа		
312	Банкинд байгаа	77,256,959.18	147,532,165.90
35	БАРАА МАТЕРИАЛ	75,226,886.70	118,322,860.70
351	Түүхий эд материал	103,800.00	4,100.00
35130	Эм боох материал	103,800.00	4,100.00
354	Хангамжийн материал	75,123,086.70	118,318,760.70
35410	Бичиг хэргийн материал	765,120.00	444,700.00
35420	Аж ахуйн материал	221,048.00	-
35450	Барилгын засварын материал	14,319,158.00	11,751,158.00
35460	Хүнсний материал	3,173,185.00	2,841,315.00
35470	Бусад хангамжийн материал	56,644,575.70	103,281,587.70
356	Мал амьтад	-	-
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,814,633,863.18	2,082,670,974.18
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,814,633,863.18	2,082,670,974.18
392	Биет хөрөнгийн дүн	1,762,143,863.18	2,030,180,974.18
39201	Барилга байгууламж	1,800,863,898.00	1,800,863,898.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(149,487,996.36)	(177,577,856.49)
39205	Машин тоног төхөөрөмж	150,965,410.22	375,120,153.22
39206	Хуримтлагдсан элэгдэл	(107,917,817.90)	(126,561,165.25)
39207	Тавилга, эд хогшил	71,126,866.13	169,501,746.13
39208	Хуримтлагдсан элэгдэл	(35,246,795.13)	(41,765,694.88)
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,628,740.00	23,628,740.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(12,045,337.84)	(15,146,887.11)
39217	Ном	20,256,896.06	22,118,040.56
393	Биет бус хөрөнгийн дүн	52,490,000.00	52,490,000.00
39301	Программ хангамж	7,743,936.00	-
39302	Хасагдуулга	(7,743,936.00)	-
39303	Бусад биет бус хөрөнгө	52,490,000.00	52,490,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,967,117,709.06	2,348,526,000.78
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,967,117,709.06	2,348,526,000.78
51	Засгийн газрын хувь оролцоо	1,967,117,709.06	2,348,526,000.78
511	Засгийн газрын оруулсан капитал	825,612,346.61	825,612,346.61
51101	Өмч: -терийн	825,612,346.61	825,612,346.61
512	Хуримтлагдсан үр дүн	(1,007,535,970.53)	(626,127,678.81)
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,007,535,970.53)	(1,007,535,970.53)
51220	Тайлант үеийн үр дүн		381,408,291.72
51300	Дахин үнэлгээний зөрүү	2,149,041,332.98	2,149,041,332.98
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	1,967,117,709.06	2,348,526,000.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлбар
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,908,568,197.00	1,471,458,745.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,965,966,197.00	357,839,345.50
120	Нийтлэг татварын бус орлого	1,965,966,197.00	357,839,345.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,965,966,197.00	357,839,345.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,445,900.00	750,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,322,648.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,890,318,605.30	281,518,617.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	71,201,691.70	71,248,080.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	942,602,000.00	1,113,619,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	730,075,300.00	961,765,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	730,075,300.00	961,765,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	212,526,700.00	151,853,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	212,526,700.00	151,853,600.00
2	Үйл ажиллагааны зардал	941,450,488.10	1,090,050,453.78
21	Урсгал зардал	941,450,488.10	1,090,050,453.78
210	Бараа, үйлчилгээний зардал	885,240,369.60	1,038,445,146.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	533,300,016.16	660,802,976.82
210101	Үндсэн цалин	391,067,065.19	489,237,031.26
210102	Нэмэгдэл цалин	116,462,539.27	143,089,122.29
210104	Урамшуулал	25,770,411.70	28,476,823.27
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	68,262,338.65	81,608,258.31
210201	Тэтгэврийн даатгалын	47,164,729.18	55,712,485.49
210202	тэтгэмжийн даатгалын	5,514,983.20	6,554,386.52
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,274,226.69	5,807,888.40
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,025,117.81	1,223,866.67
210205	ЭМ-ийн даатгалын	10,283,281.77	12,309,631.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,571,456.45	130,348,057.33
210301	Гэрэл цахилгааны зардал	8,550,556.45	11,262,857.33
210302	Түлш, халаалтын зардал	118,084,400.00	118,084,400.00
210303	Цэвэр бохир усны зардал	2,936,500.00	1,000,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,282,318.00
210401	Бичиг хэргийн зардал		1,596,420.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх		480,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		4,205,898.00
2105	Нормативт зардал	15,321,500.00	32,232,527.00
210503	Хоол, хүнс	15,321,500.00	32,003,587.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл		228,940.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,986,445.00	12,242,000.00
210604	Урсгал засварын зардал	32,986,445.00	12,242,000.00
2107	Томилолтын зардал	-	780,000.00
210702	Дотоодын томилолт	-	780,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	3,770,929.06	42,964,879.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,245,800.00	37,511,168.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,525,129.06	5,453,711.15
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	102,027,684.28	71,184,129.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,227,200.00	6,459,500.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	8,115,742.00	8,370,973.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,684,742.28	56,353,656.50
213	Урсгал шилжүүлэг	56,210,118.50	51,605,307.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	34,989,402.40	40,099,765.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	27,893,415.00	32,912,265.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	7,095,987.40	7,187,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,220,716.10	11,505,542.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,220,716.10	11,505,542.67
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		-
3	Үйл ажиллагааны үр дүн	1,967,117,708.90	381,408,291.72
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	1,967,117,708.90	381,408,291.72

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

/төгрөгөөр/			
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	947,047,900.00	1,118,692,048.00
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	3,200,000.00	5,072,648.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,200,000.00	5,072,648.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,200,000.00	5,072,648.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,200,000.00	750,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		4,322,648.00
13	<b>ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	943,847,900.00	1,113,619,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	731,321,200.00	961,765,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	731,321,200.00	961,765,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	212,526,700.00	151,853,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	212,526,700.00	151,853,600.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	869,790,940.82	1,005,544,691.28
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	869,790,940.82	1,005,544,691.28
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	813,108,827.32	949,745,156.61
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал</b>	533,300,016.16	660,802,976.82
210101	Үндсэн цалин	391,067,065.19	489,237,031.26
210102	Нэмэгдэл	116,462,539.27	143,089,122.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	25,770,411.70	28,476,823.27
210105	Гэрээт ажлын хөлс		
2102	<b>Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	68,262,338.65	81,608,258.31
210201	Тэтгэврийн даатгалын	47,164,729.18	55,712,485.49
210202	Тэтгэмжийн даатгалын	5,514,983.20	6,554,386.52
210203	ҮОМШӨ-ий даатгалын	4,274,226.69	5,807,888.40
210204	Ажилгүйдлийн даатгалын	1,025,117.81	1,223,866.67
210205	Эрүүл мэндийн даатгалын	10,283,281.77	12,309,631.23
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	129,571,456.45	130,348,057.33
210301	Гэрэл цахилгааны зардал	8,446,456.45	11,262,857.33
210302	Түлш, халаалтын зардал	118,084,400.00	118,084,400.00
210303	Цэвэр бохир усны зардал	3,040,600.00	1,000,800.00
2104	Хангамж, бараа материал	-	-
2105	<b>Нормативт зардал</b>	17,119,200.00	27,468,690.00
210501	Эм		
210502	Хоол,хүнс	17,119,200.00	27,468,690.00
210503	Нормын хувцас		
2106	<b>Эд хогшил урсгал засвар</b>	32,986,445.00	10,000,000.00
210601	Багаж техник хэрэгсэл		
210604	Урсгал засвар	32,986,445.00	10,000,000.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>		
210702	Дотоодын томиллолт		
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,740,929.06	6,003,711.15

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,245,800.00	550,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	4,495,129.06	5,453,711.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	26,128,442.00	33,513,463.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,012,700.00	25,142,490.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	8,115,742.00	8,370,973.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,682,113.50	55,799,534.67
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	35,461,397.40	44,293,992.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	28,365,410.00	37,106,492.00
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	7,095,987.40	7,187,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	21,220,716.10	11,505,542.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	21,220,716.10	11,505,542.67
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	77,256,959.18	113,147,356.72
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	-	42,872,150.00
22	Хөрөнгийн зардал	-	42,872,150.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	42,872,150.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		42,872,150.00
222001	Тоног төхөөрөмж		
223001	Бусад хөрөнгө		
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	(42,872,150.00)
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	77,256,959.18	70,275,206.72
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		77,256,959.18
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	77,256,959.18	147,532,165.90

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгсгөөр/

Үзүүдэл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
A	1	2	3	4
<b>2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>825,612,346.61</b>	<b>2,149,041,332.98</b>	<b>(2,974,653,679.43)</b>	<b>0.16</b>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			1,967,117,708.90	<b>1,967,117,708.90</b>
<b>2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>825,612,346.61</b>	<b>2,149,041,332.98</b>	<b>(1,007,535,970.53)</b>	<b>1,967,117,709.06</b>
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			381,408,291.72	<b>381,408,291.72</b>
<b>2023 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>825,612,346.61</b>	<b>2,149,041,332.98</b>	<b>(626,127,678.81)</b>	<b>2,348,526,000.78</b>

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	ХААН
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		77,256,959.18		
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,195,947,800.00	1,036,911,298.61	159,036,501.39	86.7
21	Урсгал зардлын дүн	1,195,947,800.00	1,036,911,298.61	159,036,501.39	86.7
210	Бараа үйлчилгээний зардал	1,141,177,100.00	1,036,911,298.61	104,265,801.39	90.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	774,337,800.00	660,802,976.82	113,534,823.18	85.3
210101	Үндсэн цалин	532,539,600.00	489,237,031.26	43,302,568.74	91.9
210102	Нэмэгдэл	213,498,400.00	143,089,122.29	70,409,277.71	67.0
210104	Урамшуулал	28,299,800.00	28,476,823.27	(177,023.27)	100.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,791,800.00	81,608,258.31	15,183,541.69	84.3
210201	Тэтгэврийн даатгал	65,818,400.00	55,712,485.49	10,105,914.51	84.6
210202	Тэтгэмжийн даатгал	7,743,400.00	6,554,386.52	1,189,013.48	84.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,194,700.00	5,807,888.40	386,811.60	93.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,548,600.00	1,223,866.67	324,733.33	79.0
210205	ЭМД-ын хураамж+В21	15,486,700.00	12,309,631.23	3,177,068.77	79.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	141,854,000.00	130,348,057.33	11,505,942.67	91.9
210301	Гэрэл цахилгааны зардал	14,900,400.00	11,262,857.33	3,637,542.67	75.6
210302	Түлш, халаалтын зардал	118,953,600.00	118,084,400.00	869,200.00	99.3
210303	Цэвэр бохир усны зардал	8,000,000.00	1,000,800.00	6,999,200.00	12.5
210304	Байрны түрээсийн зардал			-	
2105	Нормативт зардал	31,970,200.00	27,468,690.00	4,501,510.00	85.9
210502	Хоол хүнс	31,970,200.00	27,468,690.00	4,501,510.00	85.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	6,078,800.00	6,003,711.15	75,088.85	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	550,000.00	550,000.00	-	100.0

210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	5,528,800.00	5,453,711.15	75,088.85	98.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,144,500.00	76,385,613.00	3,758,887.00	95.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,700,600.00	68,014,640.00	3,685,960.00	94.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,443,900.00	8,370,973.00	72,927.00	99.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,770,700.00	44,293,992.00	10,476,708.00	80.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,770,700.00	44,293,992.00	10,476,708.00	80.9
213205	Төсвөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	47,583,200.00	37,106,492.00	10,476,708.00	78.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	7,187,500.00	7,187,500.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,195,947,800.00	1,107,186,505.33	88,761,294.67	92.6
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,039,021,500.00	961,765,800.00	77,255,700.00	92.6
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,039,021,500.00	961,765,800.00	77,255,700.00	92.6
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	151,853,600.00	140,348,057.33	11,505,542.67	92.42
132001	Орон нутгийн төсвөөс	151,853,600.00	140,348,057.33	11,505,542.67	92.42
120	ТӨСӨВТ БАЙГУУЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	5,072,700.00	5,072,648.00	52.00	100.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	750,000.00	750,000.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	4,322,700.00	4,322,648.00	52.00	100.0
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл		147,532,165.90	-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	41.00	41.00	-	100.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	31.00	30.00	1.00	96.8
	Үйлчлэх ажилтан	9.00	9.00	-	100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/	320.00	320.00	-	100.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургууль нь “Шударга, ёс суртахуунтай нийгэм, сүйрэлгүй байгаль орчин, хүчирхэг эдийн засаг нь тогтвортой хөгжлийн үндэс болохыг ухаарсан иргэн болгон төлөвшүүлж, аймаг улсын хэмжээний жишиг эко сургууль болох зорилго тавин, бие даасан ганц хичээлээр бус ерөнхий боловсролын сургуулийн бүх хичээл хөтөлбөрт үзэл санааг шингээж суулгах чиглэлийг баримтална” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Цахим сургалтыг сургуулийн нэгдсэн сувгаар зохион байгуулж үр дүнд хүрэх
- Эцэг ,эх ,багш, суралцагчдын хамтран ажиллах сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх
- Хүүхэд бүрийг зөв дадал хэвшилтэй болгон төлөвшүүлэх
- Бага дунд ангийн залгамж холбоог сайжруулан сурагчдад мэргэжлийн чиг баримжаатай болгоход дэмжлэг туслалцаа үзүүлэх
- Хүүхдэд эрсдэлгүй орчин бүрдүүлэхэд мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах
- Багш, ажилчдыг ажлын байрандаа тасралтгүй хөгжих боломжоор хангах

#### **Байгууллагын гадаад, дотоод орчин**

Дархан-Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургууль Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Зардлын норматив шинэчлэн батлах тухай” 2021 оны А/188 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын тухай хууль болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын “Аргачлал, зардлын норматив батлах тухай” 2022 оны А/23,27 дугаар тушаал зэргийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2021 оны А/02 дугаар тушаалаар баталж, мөн оны 01 дүгээр сараас мөрдөж эхэлсэн бөгөөд өөрчлөлт ороогүй, нягтлан бодох бүртгэлийн стандарт, санхүүгийн програмтай нийцсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 381,408.3 мянган төгрөгөөр буюу 19.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөгөөр/		
Хувийн үйлдвэр	Өмчийн үйлдвэр	Өмчийн үйлдвэр	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	77,256.9	147,532.1	70,275.2
Бараа материал	75,226.8	118,332.8	43,106.0
Үндсэн хөрөнгө	1,814,633.8	2,082,670.9	268,037.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,967,117.7</b>	<b>2,348,526.0</b>	<b>381,408.3</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,967,117.7	2,348,526.0	381,408.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,967,117.7</b>	<b>2,348,526.0</b>	<b>381,408.3</b>

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 70,275.20 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 911 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ." гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 118,332.8 мянган төгрөг болж 43,106.0 мянган төгрөгөөр өссөн нь БСГ-аас 16,563.0 мянган төгрөг, Хонгор сумын 54,686.0 мянган төгрөг буюу нийт 71249.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн аван бүртгэж, төсвийн хөрөнгөөр 98,554.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 126,706.3 мянган төгрөгийн материалыг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 103,281.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, 444.7 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 2,841.3 мянган төгрөгийн хүнсний материал, 11,751.2 мянган төгрөгийн барилгын засварын материал, 4.1 мянган төгрөгийн эм боох материал зэрэг үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,082,670.9 мянган төгрөг болж, 268,037.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БСГ-аас 102,275.0 мянган хөрөнгийн шилжүүлэн, БСГ-аас 74,384.1 мянган төгрөг, Хонгор сумын ОНХС-аас 102,238.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн аван бүртгэж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2023.11.24-ний өдрийн 01-А/333 тоот захирамжаар 7,743.9 мянган төгрөгийн программ хангамжийг акталж, тайлант онд 56,353.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн шууд захирагч 2023 оны төсвийн төсөлд нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,096,400.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 151,853.6 мянган төгрөг нийт 1,248,254.4 мянган төгрөгөөр төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,044,094.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 151,853.6 мянган төгрөг нийт 1,195,947.8 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 151,853.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 140,348.0 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 11,505,5 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвөөс

961,765.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос 814,233.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 147,532.1 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлээр улсын болон, орон нутгийн төсөв хэмнэгдсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	80111	Тогтмол зардал	151,853.60	140,348.00	(11,505.60)	92%
2	80226	Байр ашиглалттай холбоотой зардал	2,243.00	2,211.50	(31.50)	99%
3	80312	Сургалт семинарын зардал	1,105.80	1,105.80	-	100%
4	81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	2,211.50	2,211.50	-	100%
5	81801	Үдийн цай хөтөлбөр	47,583.20	40,543.60	(7,039.60)	85%
6	81816	Хүүхдэд ээлтэй орчин	48,326.40	22,851.40	(25,475.00)	47%
7	81823	Багшийн мэргэжил дээшлүүлэх зардал	4,975.90	4,975.90	-	100%
8	81834	Боловсролын стандарт	713,843.00	606,766.40	(107,076.60)	95%
9	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа хангах	164,251.80	163,537.50	(714.30)	100%
10	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургал	200	200	-	100%

11	81848	Түрээсийн сурах бичиг	550	550	-	100%
12	83603	Нэмэлт дээд шатнаас хуваарилсан	4,322.70	4,322.70	-	100%
13	81806	Дотуур байрны үйлчилгээ	54,480.90	47,287.00	(7,193.90)	87%
		<b>Нийт дүн</b>	<b>1,195,947.80</b>	<b>1,036,911.30</b>	<b>(159,036.50)</b>	<b>86.70</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагаа 2 удаа харьцуулалтын аргаар зарлаж оролцогч орж ирээгүйн улмаас шууд худалдан авалтыг хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Т.Эрдэнэтуяа гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг чанарын менежер Э.Эрдэнэбат, захирал Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн орлого үр дүнгийн тайлангийн нийт зардал 493,853.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,938.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Дархан Уул аймгийн Хонгор сумын 11 дүгээр сургуулийн 2023 оны төсвийг батлахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд цалингийн зардлыг 113,534.8 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 15,183.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 11,505.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, бараа үйлчилгээний бусад зардлыг 3,7582.9 мянган төгрөг, норматив зардлыг 4,501.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэж ажилласан байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4 шалгуур үзүүлэлтээр шалгахад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд оруулбал зохих 194 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Тус газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах 55,177.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг 100 хувийн хэрэгжилттэй байна.

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	55,177.9	3	55,177.9	100
Нийт дүн	3	55,177.9	3	55,177.9	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 76,014.2 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> 74,743.3 мянган төгрөгийг залруулж, 1,270.9 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосон байна.

Тайланд онд орлогоор хүлээн авсан 14 нэр төрлийн хөрөнгийн 3,171.0 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцоогүйг залруулсан байна.

Тайланд онд санхүүгийн орлого үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 71,572.3 мянган төгрөгийн үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг тусгаж тайлагнасныг залруулсан байна.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1 Илрүүлэлт:** Тус сургууль нь нэг хүүхдэд ноогдох хоолны зардлыг 546.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *"Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдрах ахлах ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4,300 (дөрвөн мянга гурван зуун) төгрөгөөр, бага, дунд ангийн нэг суралцагчийн хоногийн хоолны зардлыг 4,000 (дөрвөн мянган) төгрөгөөр тус тус тогтоосугай" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

**5.1.2 Илрүүлэлт:** Сургуулийн захирлын 11 дүгээр сарын 22-ны өдрийн Б/85 тоот тушаалд заасан хувиас хэтрүүлэн тооцож 2 багшид 243.7 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"* гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

**5.1.3 Илрүүлэлт:** Тус сургуулийн 6 багшид ээлжийн амралтыг давхардуулан 480.7 мянган төгрөг илүү тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т *"төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"*, 16 дугаар зүйлийн 16.5.5-т *"батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"*, Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1.Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайланд онд орлогоор хүлээн авсан 14 нэр төрлийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцоогүй байна.	1	3,171.0	1	3,171.0	-	-	1	3,171.0	-	-	-	-
Тайланд онд санхүүгийн орлого үр дүнгийн тайлангийн цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалын зардалд үдийн цай, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг тусгаж тайлагнасан	1	71,572.3			1	71,572.3	1	71,572.3				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>74,743.3</b>	<b>1</b>	<b>3,171.0</b>	<b>1</b>	<b>71,572.3</b>	<b>2</b>	<b>74,743.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус сургууль нь нэг хүүхдэд ноогдох хоолны зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.	1	546.5	1	546.5	-	-	-	-	-	-	-	-

Сургуулийн захиралын 11 дүгээр сарын 22-ны өдрийн Б/85 тоот тушаалд заасан хувиас хэтрүүлэн тооцож 2 багшид ур чадварын нэмэгдэл олгосон байна.	1	243.7	1	243.7	-	-	-	-	-	-	-	-
Тус сургуулийн 6 багшид ээлжийн амралтыг давхардуулан олгосон байна.	1	480.7	1	480.7	-	-	-	-	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1,270.9</b>	<b>3</b>	<b>1,270.9</b>	-	-	-	-	-	-	-	-